



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 30 өдөр

Дугаар А/819

Булган сум

Аймгийн Музей, Нийтийн Номын сан,
Хөгжимт жүжгийн театрын дарга нарын 2025 оны
гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, 52.2, 52.3, Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Журам батлах тухай”, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.9, 4.10 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын дэргэдэх Музей, Нийтийн Номын сан, Хөгжимт жүжгийн театрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтийн үнэлгээг хавсралтаар баталсугай.

2.Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээг үндэслэн холбогдох журмын дагуу урамшуулал олгохыг тухайн байгууллагын төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2025. оны
12 дугаар сарын 30 ны/ний өдрийн
А/819 дугаар захирамжийн хавсралт



Аймгийн Засаг даргын дэргэдэх аймгийн Музей, Нийтийн Номын сан,
Хөгжимт жүжгийн театрын 2025 оны гүйцэтгэлийн
төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтийн үнэлгээ

Д/д	Байгууллагуудын нэр	Үнэлгээ хувиар	Хугацаа
1	2	3	4
1	Музей	95.9	IV улирал
2	Хөгжимт жүжгийн театр	83.6	
3	Аймгийн Төв номын сан	92.7	